

БОЛОВСРОЛ ДАХЬ УЛАМЖЛАЛ ШИНЭЧЛЭЛИЙН АСУУДАЛ

Т.Нэмэхжаргал

Резюме:

Сейчас очень активно обсуждается в обществе проблема модернизации образования. В связи с этим, в данной статье речь идёт об основных различиях традиционной и современной тенденции развития образования.

Түлхүүр үг: боловсролын уламжлал, шинэчлэл, боловсролын зорилго, эрхэмлэх үүрэг.

Соёлын амьдралын тулгуур болсон оюуны үнэт зүйлсийг үеэс үед дамжуулан шилжүүлэх үйл явцыг уламжлал /латин хэлний traditio — дамжуулж өгөх, шилжүүлж өгөх/ гэж нэрлэдэг. Энэхүү уламжлалаар хүнд өөриймшүүлэгдэж буй Тэрхүү зүйл нь боловсрол мөн. Боловсролын үйл явцыг зохион байгуулах нэг чухал хэлбэр нь албан боловсрол билээ. Боловсролын Энэхүү хэлбэр нь нийгэм хөгжихийн хэрээр хүн төрөлхтний туршлагад хуримтлагдсан үйл ажиллагааны арга чадварыг урсгалаар өөриймшүүлэх бололцоогүй болж, мэдлэгийг түгээн дэлгэрүүлэхэд зориулагдсан байгууллага буюу сургууль, сургалтад хэрэгтэй материал буюу сурах бичиг, ямар нэг мэдлэг, мэргэжлийг түгээн дэлгэрүүлэх Мэргэжлийн хүмүүс-багш нар бий болсон тэр үеэс эхлэлтэй.

Тэгвэл боловсролын бодлогод чухам ямар үнэт зүйлс үеэс үед дамжин эрхэмлэгдэж, уламжлагдаж ирэв ээ, түүнийг эргэн нягтлах, шинэчлэх ямар шаардлага байв аа хэмээх асуултууд зүй ёсоор гарч ирнэ. Ингээд албан боловсролын хүрээнд уламжлал болон өвлөгдөж ирсэн үнэт зүйлс, тэдгээрийн өөрчлөлт шинэчлэлтийн асуудлыг товчхон эргэцүүлье.

Боловсролд XX зууны дунд үеийг хүртэл уламжлагдан ирсэн үнэт зүйлсийн гараа нь даруй XVI-XVII зууны үед хамрагддаг. шинжлэх ухааны цэцэглэн хөгжих эхлэлийг тавьж өгсөн сэргэн мандалтын үеийн дараах XVII зуун гэдэг бол шинжлэх ухаан бурхан шашны үзлээс дөнгөж

цэвэрлэгдэж эхэлсэн үе байв. Шинжлэх ухааны мэдлэгт суралцах, ертөнцийг үзэх шинжлэх ухаан ч үзлийг түгээн дэлгэрүүлэх асуудал тэр үеийн тулгамдсан зорилт байсан бөгөөд тэр нь шулуун дардан замаар яваагүйг бид мэдэх билээ. Албан боловсролыг энэхүү чухал зорилготой холбож өгөхөд жинтэй хувь нэмрийг Чехийн сэтгэгч Я.А.Коменский оруулсан байдаг.

Я.А.Коменский боловсролыг шинжлэх ухааны үнэн зөв мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх гол арга зам гэсэн үндэслэлийг дэвшүүлж хүний зөв мэргэн ухаан нь гурван үе шат дамжин төлөвшдөг гэж тэрээр үзсэн бөгөөд нэгдүгээр шат буюу онолын шат нь шинжлэх ухааны мэдлэгээр тодорхойлогддог. Энэ шатанд тавигдах гол зорилго нь бүгдийг үнэн зөв танин мэдэх явдал юм. Хоёр дахь шат буюу практик шатанд мэдлэгээ зөв зүйтэй ашиглах чадварыг багтаасан бөгөөд хүний бүхий л үйл ажиллагаа практик нь шинжлэх ухааны үнэн зөв мэдлэг дээр түшиглэх ёстой аж. Харин сүүлчийн шат буюу хэрэглээний шатанд мэдсэн сурснаа бусдад мэдээлэх чадварыг онцолж үзсэн байдаг¹. Эндээс харахад, сургалтын хамгийн эхний бөгөөд зайлшгүй алхам нь шинжлэх ухааны мэдлэг, онолд суралцах явдал байв.

Эртний үед Сократ хүний төлөвшил, ухааралд онцгой анхаарч байсан билээ. Харин Коменскийн үед шинжлэх ухааны гол эрхэмнэл болох мэдлэгийн үнэн байх чанарыг хүн бүхэн эзэмшиж, цааш түгээн дэлгэрүүлэх явдал онцгой

¹ Г.Н. Джигладзе. Философия Коменского. М.1982.с. 54-58.

байр суурь эзлэх болов. Чухам энэ үеэс эхлэн боловсролын бодлогын гол цөм нь шинжлэх ухааны үнэт зүйлсээр тодорхойлогдож иржээ. Энэ нь ертөнцийг үзэх шинжлэх ухаанч үзэл төлөвшүүлэх гэсэн тухайн үеийн чухал хэрэгцээ, шаардлагатай холбоотой нь ойлгомжтой. Тухайн эрин үеийн философид ч танин мэдэхүйн аргын боловсролын философийн үүргийг өнө удаан жил гүйцэтгэж, энэ салбарт дэвшигдсэн бүхий л асуудлыг шийдвэрлэж ирсэн байдаг.

Гэвч шинжлэх ухаанч эрхэмнэлийн дор боловсролын үйл явц гурван зууныг туулж ирэхдээ дараах хэм хэмжээг дархлаажихад хүргэсэн байна.

1. Боловсролын зорилгод шинжлэх ухааныг хэт өргөмжилсөн хэм хэмжээ бий болсон.
2. Анги танхимд хичээллэх гэдгийг шинжлэх ухаан судлал гэж ойлгоход хүрсэн,
3. Боловсролын зорилгыг шинжлэх ухааны мэдлэгийг түгээн дэлгэрүүлэх явдал гэж үзсэнтэй уялдан боловсролтой хүн гэдгийг мэргэжилтэй хүн гэсэн утгаар ойлгох болсон,
4. Хүний төлөвшил гэдгийг хүмүүжил гэдгээр орлуулах хандлага тогтож, хүмүүжлийн ажил гэдэг нь тодорхой цагаар явагддаг мэтээр хичээлийн хуваарьт тусгай цаг эзлэн байрлаж, гол хариуцагч нь ангийн багш болоход хүрсэн байна.
5. Сургалтын бодлогод шинжлэх ухааныг түүний шинжлэх ухаанч статусаар ялгаварлан үзэх хандлага дэлгэрч, хэрэгжиж эхлэв. Ялангуяа, байгаль шинжлэлийн хичээлийн нэр хүнд харьцангуй давуу байр суурь эзлэх болжээ. Үүнтэй уялдан, тухайлбал, математикт сайн хүүхэд "сайн сурагчийн" гол хэмжүүр, шалгуур боллоо. гэтэл математикт сайн байсан хүүхэд бүхэн амьдралд хөл алдахгүй гэсэн баталгаа хаана байхгүй шүү дээ.

Харин XIX зууны сүүл үеэс шинжлэх ухааныг эрхэмлэх, шинжлэх ухааны мэдлэгийг давуу байр суурьтай үнэлж, дүгнэх хандлага, хэм хэмжээ нь дараах зөрчлүүдтэй тулгарч эхэлжээ. Тухайлбал, нэгдүгээрт, мэргэшүүлэх чиглэлтэй тодорхой шаталбартай мэдлэгийг дамжуулах арга замаар

тухай асуудал зонхилох байр суурьтай тавигдаж байсан билээ. Ер нь ертөнцийг үзэх шинжлэх ухаанч үзэл төлөвшүүлэх, энэ зорилгыг боловсрол, сургалттай холбож өгсөн нь тухайн үедээ юутай ч үл зүйрлэм, томоохон дэвшил байсныг тэмдэглэх нь зүйтэй. Улмаар дээрх зарчимд тулгуурласан сурган хүмүүжүүлэх ухаан соёл дахь мэдлэгийн багтаамжийг өгөх бололцоогүй болсон. Шинжлэх ухааны мэдлэгийг тухайн шинжлэх ухааны түүх маягаар бага багаар өгч сургах үйл явц нь мэдлэг, мэдээллийн асар хурдацтай өсөлтийг гүйцэх аргагүй болсон байна. Хоёрдугаарт, боловсрол, сургалтыг дан ганц сургаж, заах, мэдээлэх маягтай дамжуулах замаар хүргэдэг болсон нь нэг талаас, хүний хүмүүнжиж төлөвших асуудлыг орхигдуулснаас ёс суртахууны олон арван асуудал дэгдэх болсон, нөгөө талаас, эзэмшсэн мэдлэгээ амьдрал практиктай уялдуулан ашиглах чадвар дутагдаж, асуудаллаг нөхцөл байдлын өмнө сэтгэлгээ хүчин мөхсөдөж, амьдралын байр суурь, баримжаагүйдэл ихэсч байгаа нь илт мэдрэгдэх болсон. Гуравдугаарт, соёл, шинжлэх ухааны хөгжлийг даган гарч ирсэн дэлхий нийтийн шинжтэй олон асуудлын шийдвэр гагцхүү боловсролтой холбоотой гэдэг нь ойлгомжтой болж ирсэн байна.

Эдгээр тулгамдсан асуудлуудад дүн шинжилгээ хийх, боловсролд зонхилох байр сууртай хэрэгжиж ирсэн загвар, хандлагад шүүмжлэлтэй хандах, улмаар онолын дүгнэлт, ойлголт дээр гол төлөв тулгуурладаг, тэдгээрийг дамжуулах замаар явагддаг хичээл сургалтын аргыг өөрчлөх, боловсролын тогтолцоог ардчилах зэрэг зорилтууд дэвшигдэн тавигдах болсон бөгөөд энэ нь угтаа боловсролын бодлогод хийгдэх шинэчлэлийн эх үндэс болсон билээ. Ийм шинэчлэлийн үзэл санаа, тухайлбал, АНУ тэргүүтэй улс орон XX зууны эхэн үеэс дэвшигдэж эхэлсэн бол, манай улсад эдүгээ үеийн тулгамдсан зорилт болоод байгаа билээ. Боловсрол бол гагцхүү хүнд заяасан үзэгдэл, хүмүүний орших арга мөн. Боловсрол олох гэдэг нь хүн төлөвших үйл явц бөгөөд энэ нь хүн

төрөлхтний соёлд хуримтлагдсан ёс суртахуун, шинжлэх ухаан, гоо сайхны үнэт зүйлсийг өөриймшүүлэх замаар хэрэгжинэ. Энэхүү өөриймшүүлэлт хүний гайхах, сонирхох, дуурайх, ярих, бодох, бичих, сонсох гэх мэт жирийн үйлдлүүдээс эхлээд шүүмжлэлтэй, хяналттай, шалгууртай, үндэслэгээтэй сэтгэж сурах, асуудалтай ажиллаж сурах, мэдлэгтэйгээ ажиллаж сурах, цаашилбал, өөрийн мэргэжлийн ур чадвараа иргэний хариуцлагатай хослуулж чаддаг, ертөнцийг үзэх зохих ёсны мэдлэгтэй, ёс суртахуунлаг иргэн төлөвшихийн төлөөх эцэс төгсгөлгүй судалгаа төрхтэй үйл явц мөн. Чухамхүү ийм бие хүний хомсдол нь манай

өнөөгийн ээдрээтэй, бэрхшээлтэй бүхний анхдагч шалтаг, шалтгаан болж байна.

Энэ бүхний эцэст тэмдэглэхэд боловсрол олох үйл явцыг өөриймшүүлэгдэж буй соёлын зөвхөн нэг хэсэг, бүрэлдэхүүн болох шинжлэх ухааны мэдлэг чамбайлан суралцах явдлаар үл хязгаарлан, аль ч соёлын орчинд бүтээлчээр амьдрах чадвар эзэмшсэн, ухаалаг иргэн төлөвшүүлэх арга хэрэгсэл гэж ойлгох нь орчин үед боловсролыг тодорхойлж буй дэлхий нийтийн жишиг, хандлага, шинэчлэлийн үндэс билээ.

Дүгнэлт болгон, боловсролын уламжлалт хандлага хийгээд орчин үеийн хандлагын гол ялгааг дараах хүснэгтээр харуулъя.

№	Үзүүлэлт	Уламжлалт хандлага	Өнөөгийн хандлага
1	Хүн	Тухайн нийгмийн зорилгодоо хүрэх арга хэрэгсэл	Нийгмийн хөгжлийн гол зорилго-үнэт зүйл
2	Боловсролын агуулга	Мэдлэг эзэмших үйл явж	Соёлыг өөриймшүүлснээр хүн төлөвших үйл явц
3	Боловсролын зорилго	Нийгмийн зорилгод нийцсэн ямар хүнийг бэлтгэх	Нийгэм-соёлын аливаа орчинд амьдрах чадвартай иргэн төлөвших
4	Боловсролын үүрэг	Хүнийг нийгэмшүүлэх, мэргэжил олгох	Хүний хөгжих, төлөвших нөхцөлийг бүрдүүлэх
5	Хүний гол эрхэмлэх зүйл	Нийтээр дагаж мөрдөх норм, хэм хэмжээнд нийцэх	Бие даан бүтээлчээр амьдрах